



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2024 оны 02 дугаар сарын 29

Дугаар 18/09

Баян-Өндөр сум

**Тогтоолд өөрчлөлт оруулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 07/09 дүгээр тогтоолоор батлагдсан “Хурлын хорооны үйл ажиллагааны журам”-ын 3.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн “Хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 18/09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас **ТОГТООХ** нь:

Хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотойгоор Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хорооны дарга Сүхбаатарын Юмэнхүү гэснийг Агваантүлтэмийн Түвшинжаргал, Төсөв, санхүүгийн хөгжлийн хорооны дарга Гомбонасангийн Эрдэнэбат гэснийг Пүрэвжавын Пүрэвлхагва, Байгаль орчин, хөдөө аж ахуйн хөгжлийн хорооны дарга Дашзэвэгийн Энхзориг гэснийг Бямбадашийн Зоригтбаяр гэж тус тус өөрчлөлт оруулсугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ